

Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх
сүлжээ ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын... 2026
оны... дүгээр сарын 10 -ны өдрийн... 1/74
дугаар тушаалын хавсралт



“БЗӨБЦТС” ТӨХК-ийн Дотоод хяналт шалгалт зохион байгуулах журмын нэмэлт, өөрчлөлт

Нэг. Компанийн “Дотоод хяналт шалгалт зохион байгуулах журам”-д дараах нэмэлтийг оруулав. Үүнд:

1.1. 2.17. “Компанийн салбар, хэлтэс, алба нь өөрийн чиг үүргийн хүрээнд дотоод хяналтыг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, эрсдэлийг урьдчилан тодорхойлох, зөрчлийг илрүүлэх, арилгах, тайлагнах хяналт аюулгүй ажиллагааны хэлтэстэй хамтран ажиллах үүрэгтэй” гэж нэмэх;

1.2. 7.7. “Хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдалтай холбоотой баримт материалыг цаасаар болон файлаар хуулбарлан авах” гэж тус тус нэмэв;

Хоёр. Компанийн “Дотоод хяналт шалгалт зохион байгуулах журам”-д дараах өөрчлөлтийг оруулав. Үүнд:

2.1. 2.15. “Компанийн харьяа салбар, хэлтэс, албаны дотоод үйл ажиллагаанд өдөр тутмын хяналтыг нэгжийн удирдлага тавих ба ХАБЭА-н II шатны үзлэг, шалгалтыг төлөвлөн гүйцэтгэж, хяналт шалгалтын тайлан, мэдээг улирал бүр гарган дараа сарын 05-ны дотор Хяналт аюулгүй ажиллагааны хэлтэст ирүүлж ажиллана” гэж заасныг “Компанийн харьяа салбар, хэлтэс, алба нь ХАБЭА-н хяналт, шалгалт хийх ажлыг “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналтын журам”-ын 6.3 дугаар заалтын дагуу зохион байгуулж, Хяналт аюулгүй ажиллагааны хэлтэст тайланг ирүүлнэ” гэж өөрчлөх;

2.2. 3.4. “Компанийн хэмжээнд тоноглолын ашиглалтын түвшин тогтоох хяналт шалгалтыг Түгээх үйл ажиллагаа хариуцсан бодлогын хэлтэс, хангах үйл ажиллагаа хариуцсан бодлогын хэлтэс, салбарын холбогдох ажилтнууд бүрэн хариуцаж ажиллана”, 3.5. “Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрмийн 5 дугаар бүлгийн 5.3, 5.4, 5.5, 5.7, 5.8, 5.9, 5.10, 5.11, 5.12 дугаар заалтуудын дагуу ашиглалтын түвшин тогтоох хяналт шалгалтыг зохион байгуулна” гэж тус тус заасныг нэгтгэж “Компанийн хэмжээнд тоноглолын ашиглалтын түвшин тогтоох хяналтыг “Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм”-ийн 5 дугаар бүлгийн 5.3, 5.4, 5.5, 5.7, 5.8, 5.9, 5.10, 5.11, 5.12 дугаар заалтуудын дагуу түгээх үйл ажиллагаа хариуцсан бодлогын хэлтэс, хангах үйл ажиллагаа хариуцсан бодлогын хэлтэс, салбарын холбогдох ажилтнууд бүрэн хариуцаж ажиллана” гэж өөрчлөх;

2.3. 9.6. “Энэхүү журмын хүрээнд хийгдсэн хяналт шалгалтын үр дүнг тухайн чиглэлийн хэлтсийн дарга нар бүрэн хариуцлага хүлээнэ” гэж заасныг “Хяналт шалгалтаар зөрчил их, эрсдэл өндөртэй шалгагдсан бол тухайн салбар, хэлтэс, албаны дарга нар уг зөрчлийг арилгуулах, дахин зөрчил гаргахгүй байх арга хэмжээ авч, холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ” гэж өөрчлөх;

2.4. 9.7. “Тухайн жилд компанийн хэмжээнд хийгдсэн хяналт шалгалтын үр дүн хангалтгүй дүгнэгдсэн тохиолдолд (өмнөх оны үзүүлэлтээс буурсан) хяналт аюулгүй ажиллагааны хэлтсийн холбогдох албан тушаалтанд хариуцлага хүлээнэ” гэж заасныг

“Хөндлөнгийн хяналт шалгалтаар зөрчил илэрсэн тохиолдолд хяналт аюулгүй ажиллагааны хэлтэс нь тухайн зөрчлийг өмнө нь илрүүлэх, мэдээлэх, зөвлөмж өгөх чиг үүргээ хэрэгжүүлсэн, түүвэр хяналтад орсон эсэхэд үнэлгээ хийгдэж, албан үүргээ биелүүлээгүй нь тогтоогдвол холбогдох албан тушаалтанд хариуцлага хүлээлгэнэ” гэж тус тус өөрчлөх;

Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2016 оны 02 дүгээр сарын 10-ны өдрийн ... А/74 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



“БЗӨБЦТС” ТӨХК-ИЙН ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ

НЭГ. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЗОРИЛГО

- 1.1 Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн Газрын шийдвэр, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ, эрх зүйн акт болон компанийн хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилт, удирдлагаас баталж мөрдүүлж буй дүрэм, журам шийдвэрийн нийцэл, түгээх, хангах, санхүүгийн болон нийтлэг үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, албан даалгавар, зөвлөмж, зөвлөгөө өгөх, эрсдэлээс сэргийлэх удирдлагаар хангаж, техник эдийн засгийн үзүүлэлтийг сайжруулахад оршино.

ХОЁР. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

- 2.1 Хяналт аюулгүй ажиллагааны хэлтэс нь эрсдэлийн түвшинд хамааруулан тухайн жилийн болон богино дунд хугацааны хяналт шалгалт хийх төлөвлөгөөтэй байх ба тус оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор гүйцэтгэх захирлаар батлуулан мөрдөж ажиллана.
- 2.2 Хяналт шалгалт нь төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, ажлын байрны гэнэтийн үзлэг шалгалт болон гүйцэтгэлийн гэсэн чиглэлтэй байна.
- 2.3 Төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, гүйцэтгэлийн хяналт шалгалтыг батлагдсан удирдамжийн дагуу гүйцэтгэнэ. ХАБЭА-н II шатны үзлэгийн удирдамжийг харьяа салбарын дарга, Хяналт аюулгүй ажиллагааны хэлтсээс зохион байгуулах хяналт шалгалтын удирдамжийг Гүйцэтгэх захирлаар батлуулна.
- 2.4 Хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд шууд буюу шууд бусаар ноцтой аюул, их хэмжээний хор хохирол учруулж байгаа буюу учруулж болох нөхцөл байдал үүссэн тохиолдолд хяналт шалгалтыг байгууллагын эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр энэ журмын 2.3-т заасан удирдамжгүйгээр хийж болно.
- 2.5 Хяналт шалгалтыг холбогдох хууль, дүрэм, журмыг баримтлан гүйцэтгэнэ.
- 2.6 Хяналт шалгалтын үр нөлөө болон мэргэжлийн чадавхыг дээшлүүлэх зорилгоор хөндлөнгийн хяналтын байгууллагаас мэргэжил, арга зүйн зөвлөгөө авах, зөрчлийг нь арилгаж чадахгүй асуудлыг хууль хяналтын эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, хамтран ажиллах талаар санал боловсруулан удирдлагад танилцуулж ажиллана.
- 2.7 Ажлын байрны үзлэг шалгалтыг эрчим хүчний ажилтны дунд зохиох аюулгүй ажиллагааны ажлын үндсэн дүрмийн 16 дугаар бүлгийн дагуу зохион байгуулна.
- 2.8 Ажилтан үзлэг шалгалт, ажил үүрэг гүйцэтгэж байхад хүний амь нас, эрүүл мэнд, нийгэм болон хүрээлэн байгаа орчны аюулгүй байдалд шууд буюу шууд бусаар ноцтой аюул, хохирол учруулж болохуйц нөхцөл байдал үүссэн нь тогтоогдвол түүнийг арилгах арга хэмжээг нэн даруй авч, компани болон салбарын удирдлага, эрх бүхий мэргэжлийн байгууллагад шуурхай мэдэгдэнэ.
- 2.9 Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчлийн шалтгаан нөхцөлийг тодруулж хариуцлага алдсан ажилтныг байлцуулан тус зөрчлийг таслан зогсоох, арилгуулах, урьдчилан сэргийлэх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч тухайн нэгжийн удирдлагад танилцуулна.
- 2.10 Хяналт шалгалтаар хариуцлага хүлээх ажилтнаас заавал бичгээр тухайн зөрчилтэй

- холбоотой тайлбар авсан байна. Хэрэв зөрчилд холбогдсон ажилтан бичгээр тайлбар өгөхөөс татгалзсан тохиолдолд энэ тухай тэмдэглэл үйлдэж баталгаажуулна.
- 2.11 Хяналт шалгалт дууссанаас хойш ажлын 7-14 хоногийн дотор тайланг захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр оруулна.
- 2.12 Хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал болон албан тушаалтанд хүлээлгэх хариуцлага, үр бүтээмжтэй ажилласан ажилтныг урамшуулах талаар захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ.
- 2.13 Хяналт шалгалтын төлөвлөгөө, гүйцэтгэл, тайлагнал, албан шаардлага, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн ажлын тайлангийн үе шат бүрийн явцын баримтыг стандартын дагуу архивд хүлээлгэн өгнө
- 2.14 Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн мөрөөр өгсөн албан даалгавар, зөвлөмжийн хэрэгжилтэд сар бүр хяналт тавьж ажиллана.
- 2.15 Компанийн харьяа салбар, хэлтэс, алба нь ХАБЭА-н хяналт, шалгалт хийх ажлыг “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналтын журам”-ын 6.3 дугаар заалтын дагуу зохион байгуулж, Хяналт аюулгүй ажиллагааны хэлтэст тайланг ирүүлнэ.
/Энэ заалтад 2026 оны 02 дугаар сарын 10-ны өдөр өөрчлөлт оруулсан/
- 2.16 Хяналтын тайланд ажлын баримт болох зөрчил дутагдлын жагсаалт, судалгаанууд, нотлох баримтууд, зураг, дүрс, дуу бичлэгүүд зэрэг холбогдох бүх баримтуудыг хавсаргана.
- 2.17 Компанийн салбар, хэлтэс, алба нь өөрийн чиг үүргийн хүрээнд дотоод хяналтыг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, эрсдэлийг урьдчилан тодорхойлох, зөрчлийг илрүүлэх, арилгах, тайлагнах хяналт аюулгүй ажиллагааны хэлтэстэй хамтран ажиллах үүрэгтэй.
/Энэ заалтад 2026 оны 02 дугаар сарын 10-ны өдөр нэмэлтээр оруулсан/

ГУРАВ. ТӨЛӨВЛӨГӨӨТ ХЯНАЛТ ШАЛГАЛТ

- 3.1 Төлөвлөгөөт хяналт шалгалтыг дараах чиглэлээр ангилна.
Үүнд:
- 3.1.1 ХАБЭА III шатны үзлэг, шалгалт;
- 3.1.2 Түгээх тусгай зөвшөөрлийн хүрээнд хийгдэх ашиглалтын түвшин тогтоох үзлэг;
- 3.1.3 Санхүүгийн үйл ажиллагаанд хийгдэх хяналт шалгалт;
- 3.1.4 Нийтлэг үйл ажиллагаанд хийгдэх хяналт шалгалт;
- 3.1.5 Хангах тусгай зөвшөөрлийн хүрээнд хийгдэх ашиглалтын түвшин тогтоох үзлэг, хэмжлийн нэгдмэл байдалд тавих хяналт шалгалт;
- 3.2 Төлөвлөгөөт хяналт шалгалтыг хяналт аюулгүй ажиллагааны хэлтэс нь харьяа салбар, хэлтэс, албанаас холбогдох албан тушаалтныг ажлын хэсэгт оролцуулан зохион байгуулж болно.
- 3.3 Компанийн хэмжээнд дэд станц, шугам тоноглол, барилга байгууламж, машин механизмд гарч болох гэмтлийг илрүүлэх, галын аюулаас урьдчилан сэргийлэх, тоноглолын бүрэн бүтэн байдалд хяналт шалгалт хийнэ.
- 3.4 Компанийн хэмжээнд тоноглолын ашиглалтын түвшин тогтоох хяналтыг “Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм”-ийн 5 дугаар бүлгийн 5.3, 5.4, 5.5, 5.7, 5.8, 5.9, 5.10, 5.11, 5.12 дугаар заалтуудын дагуу Түгээх үйл ажиллагаа хариуцсан бодлогын хэлтэс, хангах үйл ажиллагаа хариуцсан бодлогын хэлтэс, салбарын холбогдох ажилтнууд бүрэн хариуцаж ажиллана.
/Энэ заалтад 2026 оны 02 дугаар сарын 10-ны өдөр өөрчлөлт оруулсан/
- 3.5 Санхүүгийн үйл ажиллагааны хяналт шалгалтыг Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль” болон бусад холбогдох хууль, тогтоол, дүрэм журам, тушаал, шийдвэр, БЗӨБЦТС” ТӨХК-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг

- үндэслэн хяналт шалгалтыг зохион байгуулна.
- 3.6 Нийтлэг үйл ажиллагааны хяналт шалгалтын чиглэлээр Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Архив, албан бичиг хөтлөлтийн тухай хууль, Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам, ёс зүйн дүрэм, компанийн дотоод журам, “БЗӨБЦТС” ТӨХК-ийн хамтын гэрээ, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам болон бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам заавруудыг мөрдлөг болгон ажиллана.
- 3.7 Хэмжлийн нэгдмэл байдалд хяналт шалгалт хийхдээ Хэмжлийн зүйн тухай хууль, Хэмжих хэрэгсэл шалгаж баталгаажуулах норм, стандарт болон хүчин төгөлдөр мөрдөж байгаа дүрэм, журмыг үндэслэн хяналт шалгалтыг зохион байгуулна.

ДӨРӨВ. ТӨЛӨВЛӨГӨӨТ БУС ХЯНАЛТ ШАЛГАЛТ

- 4.1 Төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг Хяналт аюулгүй ажиллагааны хэлтэс удирдаж холбогдох чиглэлийн удирдлага, ИТА, ажилтан нарыг ажлын хэсэгт оролцуулж болно.
- 4.2 Удирдах дээд шатны байгууллага болон хөндлөнгийн аудит, хяналт шалгалтын дүгнэлт зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавина.
- 4.3 Хэрэглэгчээс болон ажилтнаас ирсэн санал гомдол, зөрчлийн мөрөөр хяналт, шалгалтыг зохион байгуулна.
- 4.4 Компани болон салбарын эрсдэлээс урьдчилан сэргийлэх удирдлагын тогтолцооны үр ашигтай байдалд хяналт, шалгалтын ажил зохион байгуулна.
- 4.5 Хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт, гэрээ хэлцэл, компанийн хэмжээнд хэрэгжиж байгаа бодлогын баримт бичиг, удирдлагын тушаал, шийдвэр, үүрэг даалгаврын хэрэгжилтэд хяналт шалгалт хийнэ.

ТАВ. АЖЛЫН БАЙРНЫ ГЭНЭТИЙН ҮЗЛЭГ, ШАЛГАЛТ

- 5.1 Ажилтны гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж буй байдалд үнэлэлт өгөх, тоног төхөөрөмжийн доголдол, зөрчлийг арилгуулах, хэвийн ажиллагааг хангуулах зорилгоор ажлын байрны гэнэтийн үзлэг шалгалтыг “Эрчим хүчний ажилтны дунд зохиох аюулгүй ажиллагааны ажлын үндсэн дүрэм”-ийн 16.8 дугаар заалт, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналтын журам”-ын 6.5 дугаар заалтын дагуу хяналт аюулгүй ажиллагааны хэлтэс зохион байгуулна.

ЗУРГАА. ГҮЙЦЭТГЭЛИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ

- 6.1 Гүйцэтгэлийн хяналт шалгалтыг Хяналт аюулгүй ажиллагааны хэлтэс удирдан зохион байгуулна.
- 6.2 Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт, шалгалт хийнэ.

ДОЛОО. ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙЖ БУЙ АЖИЛТНЫ ЭРХ

- 7.1 Шалгагдаж байгаа нэгжийн ажлын байранд нэвтрэн орох, удирдлагууд болон албан тушаалтантай шууд харилцаж, тэдгээрээс шаардлагатай мэдээ, судалгаа гаргуулах, холбогдох ажилтныг шалгаж танилцах, илэрсэн зөрчил, дутагдлын талаар тайлбар гаргуулж авах.
- 7.2 Хяналт шалгалтын ажлаар тухайн нэгжийн ажлын байр, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, программ хангамжийг ашиглах.

- 7.3 Санхүүгийн тайлан, баримт баталгаажуулахтай холбоотой баримт бичигтэй танилцах, холбогдох ажилтнаас гаргуулж авах, санал тавих.
 - 7.4 Өмнө хийсэн хяналт шалгалт, аудитын албан даалгавар, зөвлөмжийн хэрэгжилтийг дүгнэх, гүйцэтгэл, явцыг шалгах.
 - 7.5 Бичмэл болон цахим баримт мэдээлэл, материалыг гаргуулж авах, ашиглах.
 - 7.6 Шаардлагатай мэдээ, судалгаа, тайлбар, тодорхойлолт, бусад баримт бичгийг холбогдох албан тушаалтнаас гаргуулж авах.
 - 7.7 Хяналт шалгалтаар, илэрсэн зөрчил дутагдалтай холбоотой баримт материалыг цаасаар болон файлаар хуулбарлан авах.
- /Энэ заалтад 2026 оны 02 дугаар сарын 10-ны өдөр нэмэлтээр оруулсан/


НАЙМ. ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙЖ БУЙ АЖИЛТНЫ ҮҮРЭГ

- 8.1 Хяналт шалгалтын ажлыг хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ, ёс зүйн дүрмийг чанд баримтлан илрүүлсэн зөрчил, албан даалгавар, зөвлөмжийг хууль тогтоомж болон баримт нотолгоонд үндэслэн гаргах.
- 8.2 Хяналт шалгалтын явцад олж мэдсэн хувь хүн болон байгууллагын мэдээллийн нууцыг хадгалах, баримт бичиг, мэдээллийг зөвхөн хяналт шалгалтын үйл ажиллагаанд ашиглах.
- 8.3 Аливаа асуудалд шударга, бодит байдалд нийцүүлэн хандаж, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, аливаа дарамт, шахалт, зохимжгүй үйлдлийг хяналт аюулгүй ажиллагааны хэлтсийн дарга, гүйцэтгэх захиралд мэдээлэх.
- 8.4 Хяналт шалгалтаар илрүүлж тогтоосон зөрчлийн тоо баримт, албан шаардлага, зөвлөмжийг шалгуулсан нэгжийн удирдлага, ажилтанд танилцуулж, холбогдох баримт бичигт гарын үсэг зуруулах.
- 8.5 Хяналт шалгалт хийж буй ажилтан нь үзлэг шалгалтын эцсийн дүн гараагүй байхад үзлэг шалгалтын явц, компанийн нууцлалтай холбоотой, санхүү, эдийн засгийн үзүүлэлт болон бусад мэдээллийг чандлан нууцлах үүргийг бүрэн хүлээнэ.
- 8.6 Шалгаж буй асуудал байгууллагын нууцтай холбоотой бол нууцын ажилтанд мэдэгдэж зөвшөөрөл авсан байна.

ЕС. ХАРИУЦЛАГА

- 9.1 Хяналт шалгалт хийсэн ажлын хэсэг нь өгсөн үүрэг даалгавар биелүүлээгүй, зөрчил дутагдал гаргасан ажилтанд сахилгын шийтгэл ногдуулах саналыг боловсруулж, захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ.
- 9.2 Хяналт шалгалтын үйл ажиллагаанд ёс зүйгүй хандсан, шаардсан судалгаа, заавар, дүрэм, журам, мэдээ тайланг хугацаанд нь гаргаж ирүүлээгүй, гаргаж өгөхөөс татгалзсан, санаатайгаар алдаатай буюу хуурамчаар үйлдсэн, төлөвлөгөөт үзлэг шалгалтыг хуваарийн дагуу зохион байгуулаагүй, ажилтны илрүүлсэн зөрчлийг арилгаагүй буюу зөрчлийг мэдээлээгүй нь тогтоогдсон бол компанийн захирлын болон (салбарын дарга)-ын зөвлөлийн хурлаар хөдөлмөрийн гэрээ болон дотоод журмын дагуу хариуцлага тооцуулах асуудлыг хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.
- 9.3 Хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал нь зөрчлийн болон гэмт хэргийн шинжтэй бол хуулийн байгууллагад хандах саналыг захирлын зөвлөлд танилцуулна.
- 9.4 Хяналт шалгалт хийсэн ажлын хэсэг нь ажлаа хариуцлагагүй гүйцэтгэсэн, мэргэжлийн ур чадварын дутмаг дутуу шалгасан, эрх, үүргээ хэтрүүлэн бусдад хөндлөнгөөс нөлөөлөх оролдлого хийх, үзлэг шалгалтаар нотлогдоогүй мэдээ мэдээлэл тараах зэрэг үйлдлийнхээ өмнө бүрэн хариуцлага хүлээнэ.

- 9.5 Хяналтын ажилтан хууль зөрчсөн үйл ажиллагаа явуулсан бол түүнд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.
- 9.6 Хяналт шалгалтаар зөрчил их, эрсдэл өндөртэй шалгагдсан бол тухайн салбар, хэлтэс, албаны дарга нар уг зөрчлийг арилгуулах, дахин зөрчил гаргахгүй байх арга хэмжээ авч, холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.
/Энэ заалтад 2026 оны 02 дугаар сарын 10-ны өдөр өөрчлөлт оруулсан/
- 9.7 Хөндлөнгийн хяналт шалгалтаар зөрчил илэрсэн тохиолдолд хяналт аюулгүй ажиллагааны хэлтэс нь тухайн зөрчлийг өмнө нь илрүүлэх, мэдээлэх, зөвлөмж өгөх чиг үүргээ хэрэгжүүлсэн, түүвэр хяналтад орсон эсэхэд үнэлгээ хийгдэж, албан үүргээ биелүүлээгүй нь тогтоогдвол холбогдох албан тушаалтан хариуцлага хүлээлгэнэ.
/Энэ заалтад 2026 оны 02 дугаар сарын 10-ны өдөр өөрчлөлт оруулсан/



Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2026 оны 02 дүгээр сарын 10-ны өдрийн 1/74 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ

Хяналт шалгалтын хуудас №

1. Ажлын байр:
2. Салбар, Хэлтэс, алба:
3. Хяналт шалгалт хийх хэсэг, нэгжийн:
4. Хяналт, шалгалт хийсэн огноо:
5. Шаардлага хангасан асуулт: 6. Шаардлага хангаагүй асуулт:
7. Эрсдэл үүсэх магадлалын хувь: 8. Эрсдэл үүсэх магадлал:

Хяналт шалгалтын асуултууд, үнэлгээ

Д/д	Асуултууд	Хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын нэр, зүйл заалт	Дүгнэх оноо		Тайлбар
			Төлөвлөгөөт	Гүйцэтгэл	
1					
2					
3					
4					
5					
.					
.					
.					
15					
Нийт оноо					
Үнэлгээ					


(Шаардлага хангасан асуултыг 0 оноо, шаардлага хангаагүй асуултыг 10 оноо хүртэл дүгнэж тооцно)
 Жич: Бага эрсдэл: 0-40 %, Дунд эрсдэл: 41-80 %, Өндөр эрсдэл: 81-100 %.

Хяналт шалгалт хийсэн:

.....
 (Овог, нэр) (Албан тушаал) (гарын үсэг)

Хяналт шалгалтад хамрагдсан:

.....
 (Овог, нэр) (Албан тушаал) (гарын үсэг)



Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2026 оны 02 дүгээр сарын 10-ны өдрийн А.Н. дугаар тушаалын гуравдугаар хавсралт



БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ

Асуумж, тодруулга, тайлбар өгөх хуудас №

1. Ажилтны нэр:
2. Хаяг байршил:
3. Хэсэг нэгж:
4. Хяналт шалгалт хийсэн огноо:
5. Товч агуулга:

Д/д	Асуумж	Хариулт
1		
2		
3		
4		
5		
.		
.		
.		
.		
10		

(Ажилтан нь өөрийн өгсөн тайлбартаа бүрэн хариуцлага хүлээнэ)

Бусад:

Асуумж, тодруулга авсан:

.....
(Овог, нэр)

.....
(Албан тушаал)


.....
(гарын үсэг)

Тайлбар өгсөн:

.....
(Овог, нэр)

.....
(Албан тушаал)

.....
(гарын үсэг)



Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2022.6.02 оны дүгээр сарын 10-ны өдрийн А/З.Н. дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралт



БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ

Авто машины бэлэн байдлыг шалгах техникийн хяналтын хуудас №

1. Ажилтны нэр:
2. Авто машины дугаар:
3. Хэсэг нэгж:
4. Хяналт шалгалт хийсэн огноо:
5. Эрсдэл үүсэх хувь: 6. Эрсдэл үүсэх магадлал:

Д/д	Техникийн үзүүлэлтүүд	Дүгнэх оноо		Тайлбар
		Төлөвлөгөөт	Гүйцэтгэлийн	
1	Хөдөлгүүрийн хэвийн ажиллагаа			
2	Хурдны хайрцагны хэвийн ажиллагаа			
3	Гадна их бие, кузов			
4	Гар тормазны хэвийн ажиллагаа			
5	Гэрэл дохионы хэвийн байдал			
6	Салхины шил, шил арчигч			
7	Нөөц дугуй, дугуйны хээ, домкрат			
8	Гэрчилгээ, тусгай ангиллын үнэмлэх			
9	Татвар, оношилгоо			
10	Дуут дохио			
11	Цэвэрлэгээ, үйлчилгээ			
12	Татлаг, чирэгч			
13	Ослын гурвалжин			
14	Галын хор			
15	Эмийн сан			

(Шаардлага хангасан асуултыг 0 оноо, шаардлага хангаагүй асуултыг 10 оноо хүртэл дүгнэж тооцно)
 Жич: Бага эрсдэл: 0-40 %, Дунд эрсдэл: 41-80 %, Өндөр эрсдэл: 81-100 %.

Нэмэлт мэдээлэл:

Хяналт шалгалт хийсэн:

.....
 (Овог, нэр) (Албан тушаал) (гарын үсэг)

Хяналт шалгалтад хамрагдсан:

.....
 (Овог, нэр) (Албан тушаал) (гарын үсэг)



БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ

Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2022 оны 02 дүгээр сарын 10-ны өдрийн дугаар тушаалын тавдугаар хавсралт

Дэд станц, хуваарилах байгууламжийн ашиглалтын түвшин тогтоох хяналтын хуудас №

1. Салбар:
2. Дэд станц:
3. Хяналт, шалгалт хийсэн огноо:
4. Эрсдэл үүсэх магадлалын хувь: 5. Эрсдэл үүсэх магадлал:

Д/д	Техникийн үзүүлэлтүүд	Дүгнэх оноо		Тайлбар
		Төлөвлөгөөт	Гүйцэтгэлийн	
1	Техник ашиглалтын паспортын хөтлөлт, хадгалалт			
2	Тусгаарлагчийн бүрэн бүтэн байдал, бохирдол			
3	Тоноглол, ячейкууд дээрх ША-ны бичиглэл, нэг хаяг			
4	Газардуулах байгууламжийн ашиглалт, холболтын байдал			
5	Дэд станцын гэрэлтүүлэг, бүрэн хангалттай эсэх			
6	Дэд станцын дохиолол, реле хамгаалалт хэвийн эсэх			
7	Кабелийн сувгийн цэвэрлэгээ, хучилт, нүх сүвтэй эсэх			
8	Хаалга цоож бүрэн бүтэн эсэх			
9	Барилгын дэвэрээс ус гоождог, шалаар ус ордог эсэх			
10	Трансформаторын тосны түвшин, хэмжээ норм			
11	Трансформаторын тосны гоожилт, бохирдолт			
12	Цэнэг шавхагч, аянга зайлуулагчийн ашиглалт			
13	Шуурхай ажиллагааны схем зураг зөв, батлагдсан эсэх			
14	Гадна, дотно цэвэрлэгээ хийгдсэн эсэх			
15	Гал хамгаалагчийн ашиглалт, ажиллагаа			
16	Хэмжүүрийн трансформатор, хэмжүүр, тоолуурын ашиглалт			
17	Хуурай салгуурын контакт, губка бүрэн амссан эсэх			
18	Галын хор, багаж хэрэгслийн бүрдэлт, ашиглалт			
19	Кабелийн ашиглалт, бичиглэл (вирк)-тэй эсэх			
20	Тоноглолуудыг гадна агаарт тэсвэртэй будгаар будсан эсэх			
21	Аюулгүй ажиллагааны санамж плакатууд бүрэн эсэх			

(Шаардлага хангасан асуултыг 0 оноо, шаардлага хангаагүй асуултыг 10 оноо хүртэл дүгнэж тооцно)
Жич: Бага эрсдэл: 0-40 %, Дунд эрсдэл: 41-80 %, Өндөр эрсдэл: 81-100 %.

Нэмэлт мэдээлэл:

Үзлэг хийсэн:

.....
(Овог, нэр)

.....
(Албан тушаал)


.....
(гарын үсэг)

Танилцсан:

.....
(Овог, нэр)

.....
(Албан тушаал)

.....
(гарын үсэг)



Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2026 оны 02 дүгээр сарын 10-ны өдрийн А/74 дугаар тушаалын долоодугаар хавсралт

БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ

Салбарын тоноглолын ашиглалтын түвшин тогтоох үзлэгийн хуудас №

1. Хяналт шалгалтад хамрагдсан салбар:
2. Хяналт шалгалтад хийсэн хэсэг, нэгж:
3. Хяналт шалгалтын төрөл:
4. Удирдамжийн дугаар: 5. Хяналт шалгалт хийсэн огноо:
6. Шаардлага хангасан асуултын тоо: 7. Эрсдэл үүсэх хувь:
8. Шаардлага хангаагүй асуултын тоо: 9. Эрсдэл үүсэх магадлал:

Хяналт шалгалтын асуултууд, үнэлгээ

Д/д	Хууль тогтоомж, дүрэм, журмын нэр, зүйл, заалт	Асуултууд	Шалгалтын оноо		Тайлбар
			Төлөвлөгөөт	Гүйцэтгэл	
1	2	3	4	5	6
Нэг. Техникийн бичиг баримт					
1	ЭХ-ний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 1.5.4 заалт	Тухайн жилийн цахилгаан тоног төхөөрөмжийн их ба урсгал засварын ажлын төлөвлөгөө, түүний биелэлт, гүйцэтгэлийн акт, бичиг баримт хөтлөлт, бүрдүүлэлт			
2	ЭХ-ний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 1.2.14 заалт	Шинээр ашиглалтад орсон барилга байгууламж, тоног төхөөрөмжийг хүлээн авсан баримт бичиг, улсын комиссын актын хамт захиалагчийн архивд хадгалдаг			
3	ЭХ-ний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 1.3.14, 1.7.10 заалт	Ажилчин, инженер техникийн ажилтан бүрийн заавал мэдсэн байвал зохих дүрэм заавруудын тухай үйлдвэрийн даргын баталсан албан тушаалын заавар /ажлын байрны тодорхойлолт/ бүрд тодорхой тусгадаг. Ажилтны эрх, үүрэг, хүлээх хариуцлага, удирдах албан тушаалтан болон бусад хүмүүстэй харилцах уялдаа холбоог тусгасан			
4	ЭХ-ний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 6.5.3 заалт	Эрчим хүчний үйлдвэр, байгууллагууд нь дээд байгууллагын үлгэрчилсэн зааврын дагуу аваарын нөөц бүрдүүлсэн			
5	ЭХ-ний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 1.4.4 заалт	Эрчим хүчийг хэмнэх, цахилгаан эрчим хүчний алдагдлыг багасгах, тоног төхөөрөмжийн найдвартай, хэмнэлттэй ажиллагааг дээшлүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээнүүдийг төлөвлөн хэрэгжүүлдэг			
6	ЭХ-ний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 1.5.4 заалт	Ээлжит үзлэгийн графикийг үйлдвэрийн ерөнхий инженерээр батлуулж, мөрдөж ажилладаг			

7	ЭХ-ний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 1.5.5 заалт	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн бүрэн бүтэн байдал, аюулгүй ажиллагаа, тасралт, эвдрэл гэмтлийг бүртгэн, шалтгааныг тодорхойлох, тоноглолын ашиглалт засварын баримтыг бүрдүүлж хөтөлдөг			
8	ЭХ-ний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 1.7.1 заалт	Байгууллагын ашиглалтад байгаа тоног төхөөрөмж, байгууламжийн техникийн паспортууд нь үйлдвэрийн даргын томилсон хариуцагч нарт хадгалагдаж, ашиглалтын баримт тэмдэглэлээр тасралтгүй баяжигдан хөтлөгддөг			
9	ЭХ-ний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 1.7.2 заалт	Байгууллагын нэгж хэсгүүд, бүх ажлын байруудад заавал байвал зохих заавар, технологийн схемүүдийн жагсаалт, түүний дагуу заавар схемүүдийг боловсруулж, ерөнхий инженерээр батлуулан, ажлын байруудад тавьсан			
10	ЭХ-ний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 1.7.16 заалт	Эрчим хүчний үйлдвэр, байгууллагын үйл ажиллагаанд технологийн зөрчил /аваар саатал, тоног төхөөрөмжийн эвдрэл гэмтэл, тасралт/ гарах тухай бүр салбарын дээд байгууллагаас батлан гаргасан журам, зааврын дагуу судлах, бүртгэх, акт бичиг баримт үйлдэх			
Хоёр. Хүчний трансформаторын техник ашиглалт, аюулгүй ажиллагааны байдал					
11	ЭХ-ний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.3.1 заалт	Ачаалал, хүчдэл, тосны температурыг тогтсон норм хэмжээнд барьж ажилладаг; Хөндийрүүлэгч ба тосны үзүүлэлтүүдийг норм хэмжээнд байлгадаг, бүрэн бүтэн байлгана			
12	ЭХ-ний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.3.4 заалт	Гадна байрлалтай трансформатор, реакторын тосны бакуудад станцын буюу дэд станцын дугаар, нэр бичигдсэн байна.			
13	ЭХ-ний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.3.3 заалт	Гал унтраах суурин хэрэгслүүд, тос хүлээн авагч, тос цуглуулагч ба юүлэгчид байнга хэвийн байдалд байдаг			
14	ЭХ-ний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.3.6 заалт	Трансформатор ачаалалтай байхад хүчдэлийг тохируулагч байгууламж нь байнгын ажиллагаанд бөгөөд автомат горимд байна			
15	ЭХ-ний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.3.26 заалт	Трансформаторын гадна үзлэгийг тогтмол хийдэг, тостой тоноглолын үзлэгийн график			
16	ЭХ-ний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.3.27, 5.3.28 заалт	Трансформаторын их болон урсгал засвар, туршилтыг тогтоосон хугацаанд норм зааврын дагуу хийдэг			
17	ЭХ-ний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.3.29 заалт	Трансформаторт урьдчилан сэргийлэх туршилтыг Цахилгаан тоноглолын туршилтын норм ба зааврын дагуу хийдэг			
Гурав. Хуваарилах байгууламж					
18	ЭХ-ний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.4.1 заалт	Хуваарилах байгууламжид үйлчилдэг хүмүүс нь хэвийн болон аваарын үед ажиллах схем, заавруудаар хангагдсан			

19	ЭХ-ний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.4.4 заалт	Хаалттай хуваарилах байгууламж нь битүүмжлэл сайтай, шал нь цементийн тоос шороо бужигнахааргүй хучилттай байна			
20	ЭХ-ний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.4.14 заалт	ХХБ нь зөөврийн газардуулагч, гал эсэргүүцэх, хөдөлмөр хамгааллын хамгаалах хэрэгслүүдтэй ба анхны тусламж үзүүлэх хэрэгсэл, урьдчилан сэргийлэх плакатаар хангагдсан			
21	ЭХ-ний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.4.21 заалт	ХБ-ийн цахилгаан тоноглолуудыг "Цахилгаан тоноглолын туршилтын норм"-ийн дагуу туршигдсан			
22	ЭХ-ний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.4.6 заалт	ХБ-ийн кабелийн суваг нь галд тэсвэртэй хавтангаар тагласан, кабелийн сувгаас нүх сүв, кабелийн тусгаарлагдсан хэсгүүдийг галд тэсвэртэй материалаар чигжиж тусгаарлах, сувгууд нь байнга цэвэрхэн, ажиллагаанд бэлэн байна			
23	ЭХ-ний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.4.7 заалт	Тос хүлээн авагч, хайрган дэвсгэр, дренаж, тос зайлуулах хоолойтой			
24	ЭХ-ний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.4.12 заалт	3 кв ба түүнээс дээш хүчдэлийн хуваарилах байгууламжид газардуулга тавихад байнгын газардуулгын хутгыг ашигладаг. Газардуулагчийн бариулыг улаан, хутгыг нь хар өнгөөр будсан байна			
25	ЭХ-ний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.4.16 заалт	Хуваарилах байгууламж, тосон таслуур, тусгаарлагч, богино залгагч цахилгаан халаах хэрэгслээр тоноглогдсон, хэвийн найдвартай ажилладаг			
26	ЭХ-ний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.4.20 заалт	ХБ-ийн таслуур, хуурай салгуур, газардуулагч хутга, ачаалал таслагч, тусгаарлагч, богино холбогч зэрэг тоноглолын засвар, урсгал засварыг ерөнхий инженерийн тогтоосон хугацаанд хийж гүйцэтгэнэ			
Дөрөв. Реле хамгаалалт, автоматик					
27	ЭХ-ний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.9.1 заалт	Аваарын ба урьдчилан сэргийлэх дохиоллын байгууламжууд нь ажиллагааны бэлэн байдалд байх			
28	ЭХ-ний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.9.23 заалт	Дэд станцуудад тавигдсан РХА-ийн ажиллагаанд дүн шинжилгээ хийх, цахилгаан дамжуулах шугамд гарсан гэмтлийн байршлыг тогтоох зориулалттай аваарын үеийн бичлэгийг автомат хурдасгагчтай яриа бичигч хэмжүүрүүд, автомат осциллографик ба миний залгах байгууламж, заалтаа үлдээгч хэмжүүрүүд /Амперметр, вольтметр/ болон бусад байгууламжууд нь байнгын ажиллагааны бэлэн байна			
29	ЭХ-ний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.9.24 заалт	Шуурхай ажиллагааны гүйдлийн хэлхээн дэх хамгаалалтын аппаратууд /гал хамгаалагч, автоматүүд/ нь сонгон ажиллах чадвараар хангагдсан байх, автомат таслуур, гал хамгаалагчууд нь түүний гүйдэл ба зориулалтыг тэмдэглэсэн хяналттай байх ёстой			

30	ЭХ-ний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.4.16 заалт	ХБ-д суурилагдсан анхдагч болон хоёрдогч хэлхээний тоног төхөөрөмжүүд нь цахилгаан халаагуураар бүрэн хангагдсан, ажиллагаатай байх			
Тав. Цахилгаан дамжуулах агаарын шугам					
31	ЭХ-ний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.7.1 заалт	ЦДАШ-ын ашиглалтын явцад түүний найдвартай ажиллагааг хангахад чиглэгдсэн техникийн үйлчилгээ, засвар хийгдсэн			
32	ЭХ-ний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.7.13 заалт	ЦДАШ-д зураг төсөл, техникийн нормативын дагуу шугамын тулгуурууд дээр тавигдсан тэмдэг тэмдгэлгээ, плакатууд бүрэн тавьсан			
33	ЭХ-ний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.7.15 заалт	Агаарын шугамд хийх ээлжит үзлэгийг хугацаанд нь хийдэг, батлагдсан график, үзлэгийн тайлан			
34	ЭХ-ний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.7.25 заалт	Цахилгаан дамжуулах агаарын шугамд гарсан аваарын үед ашиглах сэлбэг материалын аваарын нөөцтэй			
35	ЭХ-ний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.7.11 заалт	Шувуу олноор үүрлэж, хөндийрүүлэгчийг их бохирдуулдаг бүсэд шувууг үргээх буюу хөндийрүүлэгч дээр суулгахгүй байх тусгай хэрэгсэл төхөөрөмж ашигладаг			
36	ЭХ-ний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.7.12 заалт	Агаарын шугам нь бусад агаарын шугамтай огтлолцсон бол дээрх шугамын утасны холбоос шаардлага хангасан			
37	ЭХ-ний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.7.19 заалт	Төмөр бетон, модон тулгуурын их засварыг тогтоогдсон хугацаанд хийдэг. 12 жилд 1-ээс доошгүй удаа			
38	ЭХ-ний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.7.10 заалт	Агаарын шугам дагуу тогтоосон өргөнтэй газрын бут сөөг, модыг тогтмол тайрч цэвэрлэж гал түймрийн аюулгүй байдлыг хангасан			
Зургаа. Газардуулах байгууламж, шугам, дэд станцын хамгаалалтын зурвас					
39	ЭХ-ний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.10.1 заалт	Газардуулагч байгууламж нь хүмүүсийн цахилгааны аюулгүй байдлыг хангах, цахилгаан тоноглолыг хамгаалах ба ашиглалтын горимын шаардлагуудыг хангасан байх			
40	ЭХ-ний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.10.5 заалт	Газардуулгын утсыг зэврэлтээс хамгаалсан байх, ил тавигдсан газардуулгын утсыг хараар будсан байх			
41	ЭХ-ний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.10.3 заалт	Төхөөрөмжийн хэсэг бүр тусдаа газардуулгын утсаар газардуулагч байгууламжид холбогдсон			
42	ЭХ-ний шугам сүлжээг хамгаалах дүрэм 2.2 заалт	Дэд станц, хуваарилах байгууламж, цахилгаан дамжуулах агаарын болон кабель шугам хамгаалалтын зурвасын зай хэмжиж хангасан байх			
43	ЭХ-ний тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2, "Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм"ийн 2.4 заалт	Эрчим хүчний шугам сүлжээний хамгаалалтын зурвасыг тогтоолгосон аймаг, нийслэл, сум, дүүргийн засаг даргын захирамж, хамгаалалтын зурваст буусан хэрэглэгчийн судалгаа, авч хэрэгжүүлсэн ажил			
Нийт оноо					

(Шаардлага хангасан асуултыг 0 оноо, шаардлага хангаагүй асуултыг 10 оноо хүртэл дүгнэж тооцно)

Жич: Бага эрсдэл: 0-40 %, Дунд эрсдэл: 41-80 %, Өндөр эрсдэл: 81-100 %.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙСЭН КОМИССЫН ДАРГА

.....
ГИШҮҮД:

.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....

.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....

ТАНИЛЦСАН:


.....
.....
.....
.....

.....
.....
.....
.....

(Албан тушаал)

(гарын үсэг)

(Овог, нэр)



Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын ...*2026* оны *02* дүгээр сарын *10* -ны өдрийн *А/74* дугаар тушаалын наймдугаар хавсралт

БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ

Хөдөлмөрийн харилцааг шалгах хяналтын хуудас №

1. Хяналт шалгалтад хамрагдсан салбар:
2. Хяналт шалгалтад хийсэн хэсэг, нэгж:
3. Хяналт шалгалтын төрөл:
4. Удирдамжийн дугаар:
5. Хяналт шалгалт хийсэн огноо:
6. Шаардлага хангасан асуултын тоо: 7. Эрсдэл үүсэх хувь:
8. Шаардлага хангаагүй асуултын тоо: 9. Эрсдэл үүсэх магадлал:

Хяналт шалгалтын асуултууд, үнэлгээ

Д/д	Хууль тогтоомж, дүрэм, журмын нэр, зүйл, заалт	Асуултууд	Шалгалтын оноо		Тайлбар
			Төлөвлөгөөт	Гүйцэтгэл	
1	2	3	4	5	6
1	Хөдөлмөрийн тухай хуулийн 24.1 заалт	Хөдөлмөрийн гэрээг ажилтан бүртэй бүрэн байгуулсан			
2	Хөдөлмөрийн тухай хуулийн 23.1, 23.2.1 заалт	Байнгын ажлын байранд хөдөлмөрийн гэрээг хугацаагүй байгуулсан			
3	Хөдөлмөрийн тухай хуулийн 48.3.2 заалт	Ажилтнаар ажлын байрны тодорхойлолтод заасан үүргийг гүйцэтгүүлсэн			
4	Хөдөлмөрийн тухай хуулийн 48.3.2 заалт	Ажил албан тушаалын жагсаалт баталж мөрдүүлсэн			
5	Хөдөлмөрийн тухай хуулийн 48.3.4, 50.1, 50.2, 50.3, 51.1, 52-57, 59.1, 60, 64.1, 66.1, 66.2, 68.1, 68.2, 69.1, 70-79 заалт	Үндсэн цалингийн сүлжээ, жишиг баталж мөрдүүлсэн			
6		Цалин хөлсийг тогтоосон хугацаанд ологдог			
7		Нэмэгдэл, нэмэгдэл хөлсийг хуульд заасны дагуу ологдог			
8		Ажил амралтын цагийг хуульд нийцүүлэн мөрддөг			
9		Ээлжийн амралтын олговор болон бусад олговрыг хуулийн дагуу олгодог			
10	Хөдөлмөрийн тухай хуулийн 23.1.2, 23.2.2 заалт	Туршилт, дагалдангаар ажиллуулахдаа хуульд заасан хугацаагаар ажиллуулдаг			
11	Хөдөлмөрийн тухай хуулийн 42.1 заалт	Ажилтанд ажлаас халагдсаны тэтгэмж ологдог			
12	Хөдөлмөрийн тухай хуулийн 125.1, 126.2 заалт	Хөдөлмөрийн маргаан таслах комисс байгуулсан, маргаан шийдвэрлэсэн эсэх			

13	Хөдөлмөрийн тухай хуулийн 5.1, 130.1 заалт	Хөдөлмөрийн дотоод журмаар зохицуулах харилцааг бүрэн тусгаж батлан мөрдүүлсэн			
14		Сахилгын шийтгэл ноогдуулсан тушаал, шийдвэрийг хууль зүйн дагуу үндэслэлтэй гаргасан			
15	Хөдөлмөрийн тухай хуулийн 111-р зүйл	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүй орон тоо тутамд төлөх төлбөрийг төлсөн			
16	Хөдөлмөрийн тухай хуулийн 144.2 заалт	25 ба түүнээс дээш ажилтантай бол нийт ажлын байрныхаа дөрвөн хувиас доошгүй орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулсан эсэх			
17	Хөдөлмөрийн тухай хуулийн 100-108 зүйл	Эмэгтэй хүний хөдөлмөрлөж ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн			
18	Хөдөлмөрийн тухай хуулийн 5, 109-112 зүйл	Насанд хүрээгүй, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настны ажиллах нөхцөл, шаардлагыг хангасан			
19	ХХДХТХ-ийн 7.1	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болон түүнээс дээш цалин олгодог			
20	Хөдөлмөрийн тухай хуулийн 78.1, 80 зүйл	Хөдөлмөр эрхлэлтийн харилцааг хуульд заасан үндэслэлээр дуусгавар болгосон, ажил олгогчийн санаачлаагаар хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцалсан шийдвэр нь хуульд засан үндэслэлтэй байх			
21	Хөдөлмөрийн тухай хуулийн 108 зүйл	Ажлын ур чадварын, ажилласан жилийн, мэргэшлийн зэргийн, хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажилласан болон бусад нэмэгдлийг хууль тогтоомж, хамтын гэрээ, хамтын хэлэлцээрт нийцүүлэн хөдөлмөрийн дотоод хэм хэмжээгээр тогтоосон эсэх			
22	Хөдөлмөрийн тухай хуулийн 109 зүйл	Ажилтанд эзгүй байгаа ажилтны үүрэг түр орлон гүйцэтгэсэн, ажлын байрны тодорхойлолтод заагаагүй нэмэлт ажил үүрэг гүйцэтгэсэн болон бусад нэмэгдэл хөлсний хэмжээг хөдөлмөрийн дотоод хэм хэмжээгээр тогтоосон эсэх			
23	ААНБ-ын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт зохион байгуулах нийтлэг журам /Засгийн газрын 311 тогтоол/	Хөдөлмөрийн доод журмын хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжүүлдэг			
Нийт оноо					

(Шаардлага хангасан асуултыг 0 оноо, шаардлага хангаагүй асуултыг 10 оноо хүртэл дүгнэж тооцно)
Жич: Бага эрсдэл: 0-40 %, Дунд эрсдэл: 41-80 %, Өндөр эрсдэл: 81-100 %.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙСЭН КОМИССЫН ДАРГА

.....
ГИШҮҮД:

.....
ТАНИЛЦСАН:

.....
(Албан тушаал)

.....
(гарын үсэг)

.....
(Овог, нэр)